



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 880

Улаанбаатар хот

Журам батлах тухай

"МУБИС-ийн дүрэм"-ийн 4.4.1, 4.4.10 дугаар заалт, Захирлын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУБИС-ийн "Суралцагчдад судалгааны тэтгэлэг олгох журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тус журмын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал /Д.Наранцэцэг/-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.МАНДАХ



• 20210465

МУБИС-ийн захирлын 2021 оны 05 сарын 12. өдрийн  
12 дугаар тушаалын хавсралт

МУБИС-ИЙН СУРАЛЦАГЧДАД СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГ  
ОЛГОХ ЖУРАМ

АТАВЗАИ 9857702

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн /цаашид МУБИС гэх/ эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийн хүрээнд бакалавр, магистр (судалгааны), докторын түвшний суралцагчдад судалгаа хийх орчин нөхцөлийг бурдүүлэх, судалгааны арга барил, ур чадварыг эзэмшиүүлэх, судлаачийн ёс зүйг төлөвшүүлэх, судалгааны ажлын үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 МУБИС-иас олгох тэтгэлгийн нөхцөл, суралцагчдад тавих шаардлага, нэр дэвшүүлэх, шалгаруулах, тэтгэлгийг олгох, түдгэлзүүлэх, цуцлах, маргаан шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.3 Тэтгэлэг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэхэд дор дурдсан үндсэн зарчмыг баримтална:
- мэдээллийг ил тод, нээлттэй хүртээмжтэй байлагах
  - эрдмийн эрх чөлеөг хангасан байх
  - судлаачийн ёс зүйг эрхэмлэх
  - судалгааны ажлын соёлыг дээдлэх
  - судалгааны онол, арга зүйд суурилсан байх.
  - шинэ мэдлэг, технологи, шинжлэх ухааны нээлтэд тулгуурласан байх
- 1.4 Энэхүү журам нь бакалаврын эчнээ, орой хэлбэрээр суралцаж буй суралцагчдад хамаарахгүй.

Хоёр. Суралцагчдад тавигдах шаардлага

- 2.1. Тэтгэлгийн шалгаруулалтад нэр дэвших суралцагч нь дараах шаардлагыг хангасан байна.

Үнд:

- 2.1.1 Бакалаврын оюутан нь 4 улирал амжилттай суралцаж 3.5 дээш голч дүнтэй байх,
- 2.1.2 Судалгааны магистрант нь 1-ээс доошгүй улирал амжилттай суралцаж 3.7 дээш голч дүнтэй байх,
- 2.1.3 Докторант нь 2-3 улиралд амжилттай суралцаж 3.7 дээш голч дүнтэй байх,
- 2.1.4 Нэр дэвшигч нь МУБИС-ийн дүрэм, журмыг зөрчсөн ямар нэгэн сахилгын шийтгэлгүй байх зэрэг болно.

Гурав. Тэтгэлэг зарлах, бүртгэх, хүлээн авах

- 3.1 Тэтгэлэг сонгон шалгаруулах тухай зарыг МУБИС-ийн вэб хуудас болон бүрэлдэхүүний сургуулиудын хөтөлбөрийн албаар дамжуулан тухайн оны 11 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 1-ны хооронд зарлана.
- 3.2 Тэтгэлэгт нэр дэвшигч нь журмын 2.1-д тавьсан шаардлагыг бүрэн хангасан байх ба мэдүүлгийн маягтыг [www.researchgrant.msu.edu.mn](http://www.researchgrant.msu.edu.mn) цахим хаягаар бөглөж, сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг зарлагдсан хугацаанд багтаан гаргана.

- Хугацаа хоцорч ирүүлсэн мэдүүлгийг хүлээн авахгүй.
- 3.3 Тэтгэлэгийн эх материалыг зарлагдсан хугацаанд бүрэлдэхүүний сургуулийн Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгсөнөөр бүртгэл баталгаажна.
- 3.4 Бүрэлдэхүүний сургуулийн Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга нь материалыг хянан нягталж, сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангана.

#### Дөрөв. Тэтгэлэг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах

- 4.1 Сонгон шалгаруулалт нь хоёр үе шаттай байна. Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтын ажлыг тэнхмийн хурлаар нээлттэй хэлэлцэж шийдвэрлэн. Хоёрduгаар шатны сонгон шалгаруулалтын ажлыг бүрэлдэхүүний сургуулийн Эрдмийн зөвлөл зохион байгуулна. Нэг ба хоерduгаар шатны сонгон шалгаруулалтыг ажлын 10 хоногт багтаан зохион байгуулна.
- 4.2 Бүрэлдэхүүний сургуулийн Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга нь шаардлага хангасан эх материалыг тэнхмийн эрхлэгч нарт хүлээлгэн өгсөнөөр нэгдүгээр шатны сонгон шалгаруулалт явагдана.
- 4.3 Нэгдүгээр шатны сонгон шалгаруулалтад тэнцсэн материалыг хүлээн авч, хоёрduгаар шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэгт хүлээлгэн өгнө.
- 4.4 Тэнхмийн багш болон Эрдмийн зөвлөлийн гишүүн нь тухайн тэтгэлэгт нэр дэвшигчтэй ашиг сонирхлын зөрчилтэй бол санал өгөх эрхгүй болно.
- 4.5 Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа тэнхмийн багш нар болон Эрдмийн зөвлөлийн гишүүд тус журмын 1.3 заасан зарчмыг баримтлан ажиллана.
- 4.6 Хоёрduгаар шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг Бүрэлдэхүүний сургуулийн захирлын тушаалаар батална. Ажлын хэсэгт бүрэлдэхүүний сургуулийн Эрдмийн зөвлөлийн гишүүд орно.
- 4.7 Ажлын хэсгийн онооны нийлбэрийн дундаж нь 80 хувиас доошгүй байх тохиолдолд нэр дэвшигчийг шалгарсанд тооцно.
- 4.8 Тэтгэлгийн үнэлгээ, дүгнэлтэд ажлын хэсгийн дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 4.9 Бакалаврын суралцагч нь дараах бичиг баримтыг бурдүүлнэ.
- 4.9.1 Зөвлөх багшийн тодорхойлолт (нийгмийн идэвх оролцоог үнэлсэн байх)
- 4.9.2 Иргэний болон оюутны үнэмлэхийн хуулбар
- 4.9.3 Сурлагын дүнгийн дэлгэрэнгүй баталгаажсан тодорхойлолт
- 4.10 Магистрант, докторантын суралцагчид дараах бичиг баримтыг нэмэлтээр хавсаргана. 4.10.1 Сурлагын дүнгийн дэлгэрэнгүй баталгаажсан тодорхойлолт
- 4.10.2 Бүтээлийн жагсаалт
- 4.10.3 Удирдагч багшийн тодорхойлолт
- 4.10.4 Гадны байгууллагын 1 эрдэмтний тодорхойлолт
- 4.11 Хоёрduгаар шатны сонгон шалгаруулалтын дүнг ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулж, Бүрэлдэхүүний сургуулийн Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгөх бөгөөд сонгон шалгарсан материалыг бусад холбогдох баримт бичгийн хамт ЭШИА-нд ирүүлнэ.
- 4.12 Шалгарсан тэтгэлгүүдийг МУБИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулж, санхүүжилтийг олгоно.
- 4.13 Судалгааны тэтгэлгийн батламжийг МУБИС-ийн захирал гардуулна.
- 4.14 Шалгарсан нэр дэвшигч нь "Судалгааны тэтгэлгийн гэрээ"-г бүрэлдэхүүний